# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН
(2025.12.06-2026.05.31)

2026 оны 06 дугаар сарын 10 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилго 1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна.** (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.7.3), (Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 3.1.2.5, 7.2.1.6), (Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.1.11), (Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө 4.7.1.5), (Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2.5, 2.6, 6.4.11, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.6.2.1, 6.4.11.1) | | | | | | | |
| Зорилт 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт<br>Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 1.1.1 | “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг шинэчилж, 2.0 хувилбарыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх | Урсгал зардал | Шинэчлэлт хийсэн эсэх; Систем ашиглалтын хувь | -/- | 1/100 | “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системийн нэмэлт хөгжүүлэлт болох 2.0 хувилбарыг нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд “Шийдвэр гаргалтад туслах хиймэл оюун AI нэвтрүүлэх” худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 06-ны өдөр зарласан. Одоогийн байдлаар системийн бүтэц, интеграцчлал, зохицуулах журмын төсөл болон хэрэглэгчийн интерфэйс (UI/UX) дизайныг боловсруулсан.<br>Мөн энэ хүрээнд Монгол Улсын хилээр нэвтрэх гадаадын иргэдийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (Mongolia Arrival Card)-ийг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, олон улсын жишиг, туршлагыг судлан шинжилгээ хийсэн. Үүний үр дүнд системийн ерөнхий бүтэц, бизнес процесс, өгөгдлийн бүтэц, интеграцчлалын архитектур, аюулгүй байдлын шаардлага, UI/UX загвар, урьдчилсан цахим мэдүүлгийн маягт, мэдээллийн сангийн загварчлал болон | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техникийн шаардлагын баримт бичгийг боловсруулсан. Тус системийг интернэтийн орчинд байршуулах m-eta.gov.mn домэйн хаяг авах хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэглэгчийн шаардлагад үндэслэсэн тест хувилбарыг дотоод орчинд ажиллагаанд оруулснаар үйлчилгээнд нэвтрүүлэх техникийн бэлтгэл хангагдсан. | |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 70 хувь | | | | | | | |
| Зорилт 2.Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна. | | | | | | | |
| 1.2.1 | Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах | Урсгал зардал | Монгол Улсын виз, зөвшөөрөл олгосон зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 26186 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 20864 иргэний визийн зөвшөөрлийг хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 5322 иргэний визийн зөвшөөрлийг боомт, орон нутаг дахь нэгжид илгээлээ.<br>Хилийн боомтод 7739, төвд 47951, нийт 55690 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон.<br>Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан хугацаа дуусаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу, албадан гаргасан хугацаа дуусаагүй шалтгаанаар 1489 иргэнд виз олгохоос татгалзсан байна. | 100 |
| 1.2.2 | Гадаадын иргэнд олгох оршин суух зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах | Урсгал зардал | Оршин суух зөвшөөрөл олгосон зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 100 | Гадаадын иргэнийг уригч 6077 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 20642 иргэний оршин суух зөвшөөрлийн олголт, 8348 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 22472 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, 2475 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр оршин суух зөвшөөрөлтэй 9165 иргэний бүртгэлд хасалт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж, 29 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 34 иргэний паспортод өөрчлөлт, 32 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оршин суух үнэмлэх дахин авах 33 иргэн, 48 цагийн бүртгэл хийлгэх 7273 иргэн, цагаачийн гарах орох мэдэгдэл хүссэн 615 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэсэн.<br>Мөн “Мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын оршин суух зөвшөөрөл олгох тухай тушаалаар 87, оршин суух зөвшөөрөл сунгах тухай 775, оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах тухай тушаалаар 17 гадаадын иргэний хүсэлтийг тус тус шийдвэрлэлээ.<br>Түүнчлэн 127 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 317 гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог улсын түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 947 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. Монгол Улсад оршин суух 43305 үнэмлэхийг шинээр хэвлэсэн байна. | |
| 1.2.3 | Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмын талаар цахим сургалт зохион байгуулах | Урсгал зардал | Мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн тоо; Сургалтын тоо | 10/- | 10/2 | Виз, зөвшөөрлийн газраас Evisa.mn системийн хүндрэл, шийдэрлэлтийн талаар Viber групп болон утсаар Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын албан хаагчдад 12 удаагийн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.<br>Иргэний харьяаллын газраас Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотод суугаа Консулын газрын дэд консул, мэргэжилтэн нартай цахимаар холбогдож, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагчаас байгууллагын даргын 2023 оны А/476 дугаар тушаалаар баталсан “Монгол | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”-ын дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газраар зуруулсан тойрох хуудсыг авч байх талаар 03 дугаар сарын 09-ний өдөр мэдээлэл хүргэж, санал солилцлоо.<br>Мөн иргэний харьяаллын асуудлаар гаргасан хүсэлтийг цахимаар авч эхлэхтэй холбоотой мэдээллийг Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгч, консулын газруудад хүргүүлэхээр ГХЯ-ны Консулын газарт 03 дугаар сарын 25-ны өдрийн 02/565 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>БНХАУ болон БНСУ-ын Элчин сайдын яамнаас 03 дугаар сарын 27, 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсан мэдээллийн арга хэмжээнд Виз зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн холбогдох албан хаагчдын хамт оролцож, Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл авах, сунгах, мөн түгээмэл тохиолддог болон анхаарах шаардлагатай асуудлын талаар аж ахуйн нэгж болон иргэдийн төлөөлөлд мэдээлэл өгөв.<br>Гадаад харилцааны яамтай хамтран Дипломат төлөөлөгчийн газарт шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтыг 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг ханган сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулж, удирдамжийн төсөл бэлтгэсэн. | |
| 1.2.4 | Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын | 100 | 100 | Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан АНУ-ын 1, БНХАУ-ын 3, АБНСириУ-ын 1, ОХУ-ын 3, Япон Улсын 1, нийт 9 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 5 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох ажиллагааг зохион байгуулах | | гүйцэтгэлийн хувь | | | иргэнд санал авахаар холбогдох байгууллагад, 4 иргэний хүсэлтэд дүгнэлт үйлдэн ЗГХЭГ-т, 4 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжиллаа. БНХАУ-ын 2 иргэний хүсэлт Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлага хангаагүй тул хүсэлтийг түдгэлзүүлсэн.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 4 иргэн тус улсын харьяат болсон байна.<br>Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын иргэн болох хүсэлтэй (БНАвстриУ-ын 18, БНКазУ-ын 52, БНСУ-ын31, БНСингапурУ-ын 1, ИБУИНХУ-ын 1, Нидерландын Хаант Улсын 4, БНХАУ-ын 3, Япон Улсын 15) нийт 125 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 131 иргэнд санал авахаар холбогдох байгууллагад, 75 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т, 105 иргэний хүсэлт, баримт бичгийг ЕТГ-т тус тус хүргүүллээ.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 удаагийн зарлигаар нийт 92 иргэн тус улсын харьяатаас гарсан.<br>Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтэд дүгнэлт үйлдэн ЗГХЭГ-т хүргүүллээ.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1 иргэний харьяаллыг сэргээн тогтоосон. | |
| 1.2.5 | Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналт тавих | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд АНУ-ын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 1 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.<br>Өнөөдрийн байдлаар Монгол Улсын харьяат 277 хүүхдийг 18 улсын гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлээд байна. | 10 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.6 | Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шийдвэрлэх, хяналт тавих | Урсгал зардал | Зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон, хяналт тавьсан ажлын гүйцэтгэл | 100 | 100 | Байгууллагын даргын дэргэдэх “Мэргэжлийн зөвлөл”-ийн 4 удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 байгууллагад шинээр олгож, 9 байгууллагын зөвшөөрлийг сунган 13 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон.<br>Нийт 63 байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж ажиллалаа.<br>Монгол Улсад өнөөдрийн байдлаар 72 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа эрхэлж байна. | 100 |
| 1.2.7 | Гадаадын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдүүдийн үрчлэлтийн дараах нөхцөл байдлын судалгаа хийж, статистик мэдээллийн бааз үүсгэх | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | “Улс хоорондын үрчлэлтийн эрх зүй ба гадаадын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн Монгол улсын харьяат хүүхдийн үрчлэлтийн дараах нөхцөл байдал” сэдэвт судалгааны ажлын эхний 3 бүлгийг хийж гүйцэтгэн 05 дугаар сарын 29-ний өдөр удирдлагад танилцуулав. | 90 |
| 1.2.8 | “Монгол Улсын иргэний харьяаллын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн тоо | - | 1 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнтэй хамтран эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зорилгоор байгууллагын даргын 02 дугаар сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/72 дугаар тушаал батлуууллаа.<br>Уг ажлын хүрээнд “Монгол Улс дахь гадаадын иргэн, харьяатын асуудал, бодлогын шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, 02 дугаар сарын 26-ны өдөр ССХ-нд хянуулахаар хүргүүлэн эцсийн хувилбарыг 03 дугаар сарын 16-ны өдөр байгууллагын даргад танилцуулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнтэй хамтран "Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн, эрх зүйн статус, бодлогын шийдэл" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 04 дүгээр сарын 15-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулсан ба тус хуралд 6 илтгэгч, 4 чиглүүлэгч, 19 панелист, 17 байгууллагын 52 зочдыг хамруулсан.<br>04 дүгээр сарын 27-ны өдөр 98 хуудас бүхий хурлын тэмдэглэлийг Стратеги судалгааны хүрээлэнд нэгтгэн хүргүүлэв. | |
| 1.2.9 | Гадаадын иргэн, түүнийг уригч иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах | Урсгал зардал | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;<br>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын зохион байгуулалтын хувь | 100/100 | 100/100 | Төлөвлөгөөт 20, төлөвлөгөөт бус 82, нийт 102 удаагийн хяналт шалгалтаар 330 аж ахуйн нэгж, байгууллага, 2746 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгасан. Хяналт шалгалтаар 199 зөрчлийг илрүүлэн 105 зөрчилд торгох шийтгэл оногдуулж, 98 гадаадын иргэнийг албадан гаргаж, 23 зөрчилд холбогдуулан албан шаардлага хүргүүлж, 1 иргэний оршин суух зөвшөөрлийг цуцалж, 3 иргэнд гарах сануулга өгсөн байна. | 100 |
| 1.2.10 | Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Урсгал зардал | Хууль зөрчсөн иргэнд авсан хориг арга хэмжээний хувь | 100 | 100 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2, 37.1.3, 37.1.6, 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн 33 улсын 421 иргэнийг 132 удаагийн тушаалаар албадан гаргав.<br>Мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.4 дэх заалтыг үндэслэн 5 улсын 11 иргэний албадан гаргасан шийдвэрийг 8 удаагийн тушаалаар цуцалсан.<br>Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь заалтыг үндэслэн 7 улсын 38 иргэнийг 34 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэв.<br>Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь заалтаар гарахыг түдгэлзүүлсэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6 улсын 26 иргэний хилээр нэвтрэх эрхийг 23 удаагийн тушаалаар сэргээж, гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. | |
| 1.2.11 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т “Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно” гэж заасныг хэрэгжүүлэх, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах | Урсгал зардал | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд болон аялал жуулчлал, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ыг холбосон мэдээллийн систем;<br>Зөрчил илрүүлэлтийн хувь | -/- | 1/100 | “Гадаадын иргэний виз бүртгэлийн нэгдсэн сан” системийг зочид буудлуудын системтэй холбох зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд FS100113_AddressRegisterRequest дугаар сервисийг хөгжүүлэн гаргаж, зочид буудлын холбооны системийг хөгжүүлэгч байгууллага болох Хореко софт ХХК-д и-мэйлээр мэдээллийг хүргүүлсэн.<br>Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийг Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем (ISF.mn), төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, E-mongolia, E-business порталаар дамжуулан хийж байгаа ба тайлант хугацаанд 17,625 гадаадын иргэнийг бүртгүүлсэн байна.<br>Мөн хугацаанд гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 60 иргэнд хамаарах зөрчлийг хянан шийдвэрлэсэн. | 90 |
| 1.2.12 | Монгол Улсаас албадан гаргаж буй гадаадын иргэний жолоодох эрх, арилжааны банкин дахь дансыг хаалгах талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх | Урсгал зардал | Хүргүүлсэн саналын тоо | 4 | 12 | Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй байсан, албадан гаргасан гадаадын 2 иргэний Голомт банкны харилцах дансыг хаалгахаар хүсэлт илгээсэн боловч Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д тус тус заасан үндэслэлээр л данс хаах, эрхийг хүчингүй болгох бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дээрх эрх зүйн зохицуулалтыг тухайлан тусгаагүй тул шийдвэрлэх боломжгүй талаар хариу мэдэгдсэн болно. | 33.3 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.13 | Виз, зөвшөөрөл, зөрчил шалган шийдвэрлэлт, иргэний харьяаллын асуудлаар иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах | Урсгал зардал | Зөвлөгөө, мэдээлэл хүргэх хэлбэр; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь; Алдсан дуудлагын хувь | 4/100/3.6% | 5/100/2.8% | Тайлант хугацаанд Монгол Улсын виз, визийн хугацааны сунгалт, албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, бүртгэлийн дугаарын олголт, ашиглалт, оршин суух үнэмлэх олгох, хэвлэх, төлбөрийн буцаалт, зөрчил шалган шийдвэрлэлт болон иргэний харьяаллын асуудлаар 42036 иргэнд утсаар, 4650 иргэнд биечлэн, 984 иргэнд цахим шуудангаар, facebook мессенжерээр 253, хиймэл оюунт чатботоор 3972 зөвлөгөө, нийт 51895 хүсэлтэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.<br>Зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 дугаарын лавлах утсанд хандсан 42848 дуудлагаас 42036 дуудлагад хариу өгч, 812 дуудлагыг алдсан нь нийт дуудлагад алдсан дуудлагын эзлэх хувь 1.9% байгааг харуулж байна. | 80 |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 82.5 хувь | | | | | | | |
| Зорилт 3.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1.3.1 | Литва Улсын Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын албатай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах | Урсгал зардал | Санамж бичиг байгуулсан эсэх | - | 1 | Бүгд Найрамдах Литва Улсын Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын албатай байгуулахаар төлөвлөж буй “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төсөл болон хоёр байгууллагын хамтын ажиллагааны танилцуулгыг 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/471 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 30 |
| 1.3.2 | “Аяллын цахим зөвшөөрөл (ETA)” болон “Хилээр нэвтрэх цахим мэдүүлгийн хуудас (Arrival Card)”-ыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын санхүүжилтийг олон улсын байгууллага, түнш орнуудын буцалтгүй тусламжаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах | Буцалтгүй тусламж | Хүргүүлсэн саналын тоо | - | 2 | “Түр ирэгч гадаадын иргэдэд зориулсан Аяллын цахим зөвшөөрөл (Electronic travel authorization) болон Хилээр нэвтрэх цахим мэдүүлгийн хуудас (Arrival card)-ыг Монгол Улсад нэвтрүүлэх ач холбогдлын тухай танилцуулгыг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2343 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.3 | Монгол Улс дахь гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажил хийх | Урсгал зардал | Судалгаа хийсэн эсэх | - | 1 | Монгол Улс дахь гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажлын бүтэц, агуулгыг боловсруулж, олон улсын туршлагыг харьцуулан судлах зорилгоор сонгогдсон улс орнуудын бодлого, тогтолцоо, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг цуглуулан судалж байна. | 30 |
| 1.3.4 | Гадаад сургалт, олон улсын хурал уулзалтад албан хаагчдыг оролцуулах | Буцалтгүй тусламж | Хамрагдсан албан хаагчийн тоо | 62 | 63 | Тайлант хугацаанд давхардсан тоогоор 12 албан хаагч гадаад улсад зохион байгуулагдсан 8 удаагийн сургалт, олон улсын хурал, уулзалтад хамрагдсан байна. Үүнд:<br>- 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 21-ний өдрүүдэд БНХАУ-ын Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Олон улсын хууль зүйн солилцоо, хамтын ажиллагааны сургалтын төвд зохион байгуулагдсан "Монгол Улсын дунд, дээд зэргийн офицерын сургалт"-д Мэдээллийн технологийн хэлтсийн дарга болон Увс аймаг дахь хэлтсийн дарга оролцов.<br>- 2026 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн нар Бүгд Найрамдах Сингапур Улсын Цагаачлал, хилийн хяналтын газрын төлөөлөгчидтэй албан уулзалт хийсэн.<br>- 02 дугаар сарын 23-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Унгар Улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан ГИХГ-ын албан хаагчдад зориулсан | 38.1 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн дарга, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Өмнөд бүс дэх газрын хяналтын улсын байцаагч нар хамрагдсан.<br>- 02 дугаар сарын 23-ны өдрөөс 26-ны өдрүүдэд байгууллагын дарга болон ГХСХАХ-ийн дарга БНСУ-ын Сөүл хотноо Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэргийн яамд хоорондын Консулын XII зөвлөлдөх уулзалтад оролцлоо.<br>- 02 дугаар сарын 23-ны өдөр байгууллагын дарга болон ГХСХАХ-ийн дарга БНСУ-ын Сөүл хотноо тус улсын ХЗЯ-ны харьяа Цагаачлалын албаны даргатай албан уулзалт хийв.<br>- 02 дугаар сарын 24-ний өдөр байгууллагын дарга болон ГХСХАХ-ийн дарга БНСУ-ын Сөүл хотноо Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвийн даргатай албан уулзалт хийсэн.<br>- 05 дугаар сард Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд БНСУ-ын Хууль зүйн сайдтай хийсэн албан ёсны уулзалтад байгууллагын дарга оролцсон.<br><br>ЗУГ-ын тайлан төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтнийг Тайваньд 05 дугаар сарын 08-ны өдрөөс 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Үндэсний хөгжлийн 184 дэх удаагийн семинар”-т хамруулав. | |
| 1.3.5 | Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл | Урсгал зардал | Санал хүргүүлсэн хууль тогтоомж; | 10/6 | 10/6 | Хуулийн төсөлд 2, Засгийн газрын тогтоолын төсөлд 1, сайдын батлах тушаалд 1, эрх зүйн | 62.5 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох | | Боловсруулж баталсан эрх зүйн баримт бичгийн тоо | | | баримт бичиг боловсронгуй болгох чиглэлд 1 санал боловсруулан хүргүүлсэн. Үүнд:<br>-Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлээс 01 дүгээр сарын 21-ний өдрийн УИХ-03/864 дугаар албан бичгээр ирүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй танилцаж, 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/283;<br>- ХЗДХЯ-ны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/2156 дугаар албан бичгээр ирүүлсэн Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 05 дугаар сарын 14-ний өдрийн 02/912;<br>- ХЗДХ-ийн сайдын 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/908 дугаар албан бичгээр ирүүлсэн “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын төсөлд 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/411;<br>- ХЗДХ-ийн сайдын 2014 оны А/90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар”-ын холбогдох зохицуулалтыг өөрчлөх 9, өөрчлөн найруулах 1, хасах 2 саналыг 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1001 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Мөн байгууллагын даргын 2026 оны А/23, ХЗДХ-ийн сайдын 2026 оны А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Гадаадын иргэний эрх зүйн байдлыг тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.6 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 97.9 | 100 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 02 дугаар сарын 06-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан.<br>Тус төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх газрын 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03/951 дүгээр албан бичгээр ирүүлсэн зөвлөмжид заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох 9 зорилтыг тусгасан.<br>Баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах хугацаа заасан чиглэлийг Захиргаа, удирдлагын газрын даргын 02 дугаар сарын 11-ний өдрийн 02/292 дугаар албан бичгээр нэгжүүдэд хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 44 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргасан байна. Үүнд:<br>- Төрийн бусад байгууллагаас шилжүүлэн ажиллуулах-5;<br>- Нэгж дотор, нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах-11;<br>- Дэвшүүлэн томилох-1;<br>- Шинээр томилох-17;<br>- Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх-10.<br>“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем”-д үүсгэсэн мэдүүлэг гаргах 211 албан тушаалтны 2025 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/348 албан бичгээр батлагдсан маягт, зөвлөмж зааврын дагуу нэгтгэсэн “ХАСХОМ-ийн 2025 оны тайлан”-г хавсралтаар, мөн ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг цахимаар тус тус хүргүүлсэн.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор нэгжийн дарга нарын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах 2 арга хэмжээний саналыг боловсруулж, тусгуулсан. | |
| 1.3.7 | Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 91 | 100 | Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг Захиргаа, удирдлагын газрын 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02/10 дугаар дотоод албан бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдээс санал авч, 11 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 02 дугаар сарын 06-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан.<br>Төлөвлөгөөний хүрээнд давхар ажил эрхлэлттэй холбоотой хориглолт, хязгаарлалтын талаарх зөвлөмж боловсруулж, байгууллагын даргын 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/442 албан бичгээр мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглосон зохицуулалтыг зөрчсөн нь Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон Агаарын замын боомт хариуцсан газрын хяналтын улсын байцаагчид байгууллагын даргын Б/96 тушаалаар албан тушаалын цалинг 3 сарын | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаатай 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан.<br>Мөн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны саналын дагуу хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, сахилгын шийтгэл, ёс зүйн хариуцлагын талаарх мэдээллийг сар бүрийн 02-ны өдрийн дотор өмнөх сарын дүнгээр erp.e-mongolia.mn (төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем)-д 5 удаагийн мэдээлэл байршуулсан. | |
| 1.3.8 | Төрийн тусгай албаны албан тушаалын сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх | Урсгал зардал | Сонгон шалгаруулалтын тоо | 3 | 5 | Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсаар 5 удаа нээлттэй зарласан төрийн тусгай удирдах 1, гүйцэтгэх 21, нийт 22 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 01 дүгээр сарын 13, 15, 04 дүгээр сарын 08, 05 дугаар сарын 01, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>5 удаагийн тусгай шалгалтад бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 85 иргэнээс шаардлага хангасан 26 иргэнийг бүртгэж, 60 ба түүнээс дээш оноогоор тухайн албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн 17 иргэнийг Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилж, зарлагдсан сул орон тооны 77.2 хувийг нөхсөн. | 100 |
| 1.3.9 | Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг Захиргаа, удирдлагын газрын 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02/10 дотоод албан бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдээс санал авч, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 02 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. Энэ | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>-Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.20-д заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах саналын төслийг боловсруулж, 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/501 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>-“Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”-ын дагуу чиг үүргийн онцлогийг харгалзан 62 албан хаагчийг харьяалах нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу 7 хоногийн 1 өдөр зайнаас ажиллуулсан.<br>-“Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 50 албан хаагчид олговортой, бусад шалтгаанаар 36 албан хаагчид олговоргүй чөлөө олгосон.<br>-Төв байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй, сургуулийн насны хүүхэдтэй 2 албан хаагчийн хүсэлт, нөхцөлийг харгалзан харьяалах нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу богиносгосон цагийн хуваариар ажиллуулж байна.<br>-Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд Баруун болон Зүүн бүс дэх газарт орон нутгийн хөрөнгөөр 595.8 сая төгрөгийн өртөгтэй 2 орон сууц, 299.0 сая төгрөгөөр 1 автомашин авч, зураг төсвийн болон урсгал засварын зардалд Өмнөд болон Баруун бүс дэх газарт орон нутгийн төсөв 21.8 сая төгрөг зарцуулсан. | |
| 1.3.10 | Байгууллагын 2026 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын 2026 оны сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2025 оны 12 дугаар сард албан хаагчдаас цахим судалгаа авч, дүнг 12 дугаар сарын 31-ний өдрийн 01- | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 02/123 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Албан хаагчдын саналыг сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгаж, Гадаадын иргэн, харьяатын газрын 2026 оны сургалтын төлөвлөгөөг 02 дугаар сарын 09-ний өдөр байгууллагын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд нийт 20 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1,200 гаруй албан хаагчийг хамруулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй. | |
| 1.3.11 | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 100 | Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 15 арга хэмжээтэйгээр 02 дугаар сарын 27-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:<br>Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулах тухай саналыг 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/477 дугаар албан бичгээр Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлсэн.<br>Байгууллагын даргын 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Удирдах албан тушаалтны сургалт зохион байгуулах тухай” А/16 дугаар тушаалын дагуу 01 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн удирдах албан тушаалтнуудын нэгдсэн цугларалтад, 03 дугаар сарын 02-ны өдрийн "Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт зохион байгуулах тухай" 01-02/11 дүгээр удирдамжийн дагуу 03 дугаар сарын 05-ны өдөр шинээр томилогдож буй албан хаагчдад, Зөвлөгөө, мэдээлэл хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах тухай 05 дугаар сарын 21-ний өдрийн 02/27 дугаар удирдамжийн дагуу 05 | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 25-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад тус тус сургалт орлоо.<br>Удирдах албан тушаалтнуудын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдаа соён гэгээрүүлэх аян зохион байгуулах талаар хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нартай 05 дугаар сарын 26-ны өдөр байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны албан хаагчид цахим уулзалт зохион байгуулж, санал солилцлоо.<br>Тайлант хугацаанд 2 албан хаагчид гомдол ирүүлснийг хүлээн авч hrm.csc.gov.mn "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, гомдлыг шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн.<br>Байгууллагын цахим хуудсанд төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмын талаарх танилцуулга бүхий мэдээллийг 05 дугаар сарын 22-ны өдөр байршуулсан. | |
| 1.3.12 | Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Урсгал зардал | Судалгааны тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | 1/- | 1/100 | Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу анкетын аргаар төв болон хилийн боомт орон нутаг дахь нэгжийн 131 албан хаагчдаас ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тогтоох зорилготой 12 асуулга бүхий судалгаа авч 05 дугаар сарын 29-ний өдөр үр дүнг нэгтгэлээ.<br>Анкетын судалгааны явцад илэрсэн асуудлыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ярилцлага буюу “Чанарын судалгаа” авахаар 7 асуулга бүхий судалгааны асуулт бэлтгэн албан хаагчдаас авахаар ажиллаж байна. | |
| 1.3.13 | Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | 100 | Байгууллагын дэргэдэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон тооны бус зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулж, 02 дугаар сарын 24-ний өдөр байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд “Харилцан хүндэтгэе” аяныг байгууллагын хэмжээнд 03 дугаар сард зохион байгуулж, ажлын тайланг 03 дугаар сарын 30-ны өдрийн 02/601 дугаар албан бичгээр Жендэрийн үндэсний хороо болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийн тайланг 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/895 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 90 |
| 1.3.14 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 92 | 100 | Гадаадын иргэн, харьяатын газрын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г нийт 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 02 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл болон Үндэсний зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1, 2 дугаар улирлын хэрэгжилтийн тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүллээ.<br>Тайлант хугацаанд 2 албан хаагчийн хүсэлтийн дагуу зайнаас болон богиносгосон цагаар ажиллуулах хуваарийг батлуулж, нэгжид нь хүргүүлсэн. | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг үнэлэх, дэмжлэг шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч болон гэр бүлийн гишүүдийн судалгаа”-г 04 дүгээр сарын 02-10-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж, нийт 297 албан хаагчаас 205 буюу 69 хувь нь хамрагдлаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос хараны бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн 260,000 төгрөгийн үнэ бүхий дугтуй, 112,000 төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг саванг тус тус худалдан авч, албан хэрэгцээнд ашиглаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн үйлчилгээний бүртгэлийг системчилж, мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор "Бүртгэлийн дэвтэр"-ийг шинээр нээн төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлэн, хөтлүүлсэн ба тайлант хугацаанд нийт 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн үйлчилгээ авсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай. | |
| 1.3.15 | “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төсөлд санал хүргүүлэх | Урсгал зардал | Төсөлд санал хүргүүлсэн эсэх | 1 | 1 | "Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө"-ний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/554 дүгээр тушаалаар байгуулан саналыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу нэгтгэн боловсруулж, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. | |
| 1.3.16 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын 2026 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 9 бүлэг 16 заалттайгаар 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр батлуулж, 01 дүгээр сарын 15-ны өдөр төрийн цахим шуудангаар төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлсэн.<br>Төлөвлөгөөний хүрээнд 03 дугаар сарын 12-ны өдөр гардан тулааны спортын мастер, сургагч багш Б.Чулуунбаатартай хамтран 30 хяналтын улсын байцаагчид “Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх нь”, 03 дугаар сарын 20-ны өдөр “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нь” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, нийт 185 албан хаагчийг хамруулсан.<br>Байгууллагын болон албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор төв байрны нэг давхрын дотор шилэн хаалганд карт уншигч төхөөрөмж суурилуулсан.<br>Мөн 2, 3 давхар болон Мэдээллийн технологийн хэлтсийн албаны өрөө, байрны гадна болон дотор талууд, орон нутаг дахь нэгжийн албаны өрөө тасалгаанд камер суурилуулан нийт 93 камерт хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ оны 06 дугаар сарын 14-ний өдрөөр нэгтгэн танилцуулахаар төлөвлөж байна. | 100 |
| 1.3.17 | Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэг, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх | Урсгал зардал | Байгууллагын цахим хуудаст нийтэлсэн мэдээллийн тоо; | 160/246/609 | 160/246/609 | Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 44 мэдээ бэлтгэж, байгууллагын цахим хуудаст нийт 106 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээлэл байршуулан олон нийтэд ил тод мэдээллээ. Мөн байгууллагын олон нийтийн цахим | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээллийн тоо; Сурталчилсан тоо | | | сүлжээнд нийт 154 мэдээлэл байршуулав. Цахим сүлжээнд тогтмол мэдээлэл байршуулснаар байгууллагын цахим сүлжээн дэх хуудас 40 мянган дагагчтай, дундаж хандалт 100, 000 байна. Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 389 хэвлэл мэдээллийн хэрэгслээр (357 сайт, 16 сонин, 16 телевиз) сурталчилсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн нийт 51 мэдээллийг нээлттэй байршуулсан. Шилэн мэдээллийн сан буюу **shilen.gov.mn** сайтын нээлттэй мэдээллийн ил тод байдал нэгдүгээр улиралд 99.09 хувиар үнэлэгдсэн. | |
| 1.3.18 | Байгууллагад ирсэн, байгууллагаас явуулсан албан бичгийн эргэлтийг зохион байгуулах | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | 90 | 100 | Тайлант хугацаанд байгууллагад ирүүлсэн хариутай 584, хариугүй 1705, нийт 2289 албан бичгийг хүлээн авч, бүртгэл хөтөллөө. Хариутай албан бичгээс 560 албан бичиг хугацаандаа шийдвэрлэгдэж, 24 албан бичгийг шийдвэрлэх шатанд судалж байна. Байгууллагаас холбогдох байгууллага, албан тушаалтанд явуулсан 1026 албан бичгээс 739 албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар хүргүүлж, 201 бичгийг шууданд хүлээлгэн өгч, 86 бичгийг байгууллага, иргэнд гарт нь олгосон байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.19 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх | Урсгал зардал | Шийдвэрлэлтийн хувь | 97.2 | 100 | Тайлант хугацаанд байгууллагын төвд 276 (иргэнээс 213 өргөдөл, 2 талархал, 22 гомдол, албан хаагчдаас 38 өргөдөл, 1 гомдол), хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 85 (иргэнээс 43 өргөдөл, албан хаагчдаас 42 өргөдөл), нийт 361 өргөдлийг хүлээн авч, өмнөх жилийн үлдэгдэл 20 өргөдлийн хамт нийт 347 өргөдлийг шийдвэрлэснээс хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 1 өргөдөл байна.<br>Үүнээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс манай байгууллагад 2 талархал, 2 санал, 2 хүсэлт, 22 гомдол шилжүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн.<br>Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт өссөн дүнгээр 96.1 хувьтай, хуулийн хугацаанд буюу шийдвэрлэх шатанд 34 өргөдөл хянагдаж байна. | 90 |
| 1.3.20 | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Урсгал зардал | Үнэлгээ хийсэн тоо;<br>Хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 19/19 | 20/20 | Бодлогын баримт бичигт 6, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 5 нийт 11 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг тухай бүр холбогдох газарт хүргүүлэв. Үүнд:<br>-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/2243 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 2026 оны нэгдүгээр улирлын болон Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолын, Засгийн газрын 2026 оны 115, 119 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын тогтоолын дагуу хүний эрх, эрх чөлөө болон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөөний Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний нэгдүгээр улирлын хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээ хийж тайланг холбогдох газар, нэгжүүдэд хүргүүлсэн.<br>-Бодлогын баримт бичиг буюу “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/2243 дугаар албан бичгээр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2025 оны хэрэгжилтэд тус бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/2180 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө, Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тус тус жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр удирдлагад танилцуулсан. | |
| 1.3.21 | Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Урсгал зардал | Үнэлгээ хийсэн тоо;<br>Хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 16/16 | 17/17 | Байгууллагын үйл ажиллагаанд 13 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 12 дугаар сарын 03, 11, 01 дүгээр сарын 07, 13, 15, 02 дугаар сарын 09, 03 дугаар сарын 09, 04 дүгээр сарын 09, 05 дугаар сарын 07-ны өдөр тус тус байгууллагын даргад танилцуулсан. Үүнд:<br>-Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлан; | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлан;<br>-Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөө болон хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлан;<br>-2025 оны 11, 12 дугаар сар, 2026 оны 01-04 дүгээр сарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан;<br>-Төв болон орон нутаг дахь төсвийн шууд захирагч болон нэгжийн дарга нарын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл;<br>-Төв болон орон нутаг дахь 16 нэгжийн нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;<br>-Байгууллагын 2025 оны нээлттэй мэдээллийг ил тод байдал;<br>-Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт. | |
| 1.3.22 | Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх | Урсгал зардал | Тайлангийн тоо | 2 | 2 | Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ын дагуу байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн 2025 оны тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/193 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/326 дугаар албан бичгээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаар зөвлөмж ирүүлсний дагуу 04 дүгээр сарын 01-ний өдөр байгууллагын 2026 оны эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. Байгууллагын эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний энэ оны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрсдэлийн үнэлгээний тайлангийн хамт 06 дугаар сарын 05-ны өдрийн 08/1053 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв. | |
| 1.3.23 | Нийцлийн болон санхүүгийн аудитын хяналт шалгалтыг зохион байгуулах | Урсгал зардал | Хяналт шалгалтын тоо; Хүргүүлсэн зөвлөмжийн тоо | 9/9 | 9/9 | Байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүү болон тушаал шийдвэр, гэрээний хэрэгжилтэд 2, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, нийт 4 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Байгууллагын даргын 04 дүгээр сарын 27-ны өдөр 01-08/04 дүгээр удирдамжийн дагуу 2026 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд нийцлийн болон дотоод аудитын хяналт шалгалтыг хийж үр дүнг 05 дугаар сарын 11-ний өдрийн 01-08/09 дүгээр илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж, зөвлөмжийг Санхүү, хангалт үйлчилгээний газарт 05 дугаар сарын 13-ны өдрийн 08/19 дүгээр дотоод албан бичгээр хүргүүлэв.<br>- Байгууллагын даргын баталсан энэ оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01-08/05 дугаар удирдамжийн дагуу Баруун бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн хүрээнд батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд 05 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийн хооронд дотоод болон нийцлийн аудит зохион байгуулж, хяналт шалгалтын үр дүнг 06 дугаар сарын 05-ны өдрийн 01-08/11 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулав.<br>- Байгууллагын даргын энэ оны 01-08/01, 01-08/03 дугаар удирдамжийн дагуу төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн шилэн дансны тухай хуулийн 2025 оны дөрөвдүгээр улирал, 2026 оны 1 дүгээр | 88.9 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийн, 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01-08/03, 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01-08/08 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Шилэн дансны зөвлөмжийг 04 дүгээр сарын 23-ны өдрийн 08/748 дугаар албан бичгээр Баруун бүс дэх газар, Хойд бүс дэх газарт хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан. | |
| 1.3.24 | Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлийг боловсруулж, системд сар бүр нийтлэх | Урсгал зардал | Нээлттэй өгөгдлийн тоо; Нийтэлсэн тоо | 11/12 | 11/12 | “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын дагуу мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг 2025 оны 12 дугаар сар, 2026 оны 01-04 дүгээр сарын байдлаар XLSX, CSV, JSON өргөтгөлөөр тус тус боловсруулж, холбогдох хугацаанд байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д нийтэллээ. | 100 |
| 1.3.25 | Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны статистикийн эмхэтгэл гаргах | Урсгал зардал | Эмхэтгэл гаргасан эсэх | 1 | 1 | Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны статистик эмхэтгэл боловсруулахтай холбогдуулан хилийн боомт, орон нутаг дахь газар, нэгжүүдийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгахаар үндсэн үйл ажиллагааны 2024, 2025 оны мэдээг нэгтгэх хүснэгт бэлтгэн 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08/118 дугаар дотоод албан бичгээр илгээсэн. Эмхэтгэлийн эх бэлтгэлийг боловсруулан төслийг 05 дугаар сарын 15-ны өдрийн 01-08/10 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж, байгууллагын сайтад байршуулан олон нийтэд нээлттэй хүргэсэн. | 100 |
| 1.3.26 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах | Урсгал зардал | Батлагдсан төсөв; Гүйцэтгэлийн дүн | 18.8/14.4 тэрбум төгрөг | 20.2/20.2 тэрбум төгрөг | Энэ онд 20,236.1 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01/195, 01/363, 01/560, 01/787, 01/997 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлж, шийдвэрлүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.27 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансад холбогдох байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах | Урсгал зардал | Зөвлөмж;<br>Акт;<br>Албан шаардлага авсан эсэх (өсөлт, бууралт) | 3/0/3 | 3/0/3 буурууллна | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг байгууллагын даргын 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/427 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн ба санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Тус аудитын шалгалтаар 3 төлбөрийн акт, 6 албан шаардлага, 3 зөвлөмж авсан. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/566 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 50 |
| 1.3.28 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан худалдан авах ажиллагааны 2026 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах | Урсгал зардал | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 91 | 100 | Байгууллагын 2026 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 9 төсөл арга хэмжээ зохион байгуулагдахаас 8 төсөл арга хэмжээний зарыг цахим системд байршуулж, 1 төсөл арга хэмжээг цахим дэлгүүрээс худалдан авахаар зарыг байршуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>“Интернэт болон сувгийн холболтын үйлчилгээ”, ”Тээвэр шатахуун бэлтгэн нийлүүлэх”, “Улсын мэдээллийн маягт бэлтгэн нийлүүлэх”, “Багаж техник хэрэгсэл нийлүүлэх” 2 удаагийн гэрээ, “Мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах”, Баян-өлгий аймаг дах хэлтсийн “Барилгын ажил гүйцэтгэх” нийт 7 гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан ба “Нормын хувцас бэлтгэн нийлүүлэх” төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг дахин зарлаж, “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийн 2.0 хувилбарыг хөгжүүлэх хүрээнд “Шийдвэр гаргалтад туслах хиймэл оюун AI нэвтрүүлэх” болон “Оршин суух үнэмлэх хэвлэх бараа | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | материал бэлтгэх", "Цахим шинэчлэлтэд шаардагдах багаж техник хэрэгсэл бэлтгэх" 3 төсөл арга хэмжээний нээлтийг хийж, үнэлэх ажлыг зохион байгуулж байна.<br>Худалдан авах ажиллагааны тайланг улиралд нэг удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, www.shilendans.gov.mn сар бүр мэдээлсэн болно. | |
| 1.3.29 | Тэмдэгтийн хураамж, торгууль, үйлчилгээний хураамжийн орлогыг улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавих | Урсгал зардал | Төвлөрүүлсэн орлогын дүн | 31.7 тэрбум төгрөг | 30.0 тэрбум төгрөг | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төвлөрүүлж буй визийн үйлчилгээний хөлс, оршин суух үнэмлэх хэвлэх хураамжийн орлого болох 2,309.2 сая төгрөгийг улсын төсөвт, орон нутгийн төсөвт 871.8 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 13,753.3 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тус тус төвлөрүүлсэн ба хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн орлого төвлөрүүлэлтэд сар бүр буюу 5 удаа хяналт тавьж, нэгтгэл тайланг гаргасан. | 91.3 |
| 1.3.30 | Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн иргэдэд үйлчлэх албаны байрны барилгын ажлыг эхлүүлэх | Улсын төсөв | Барилгын ажлын явцын хувь | - | 30 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 04 дүгээр сарын 30-ны өдрийн 170 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн албаны хуучин барилгыг акталсан.<br>Иргэдэд үйлчлэх албаны шинэ байрны барилгын ажлыг гүйцэтгэх тендэр шалгаруулалтад Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулж буй "Лау Лау" ХХК шалгарч, 05 дугаар сарын 28-ны өдөр ХЗДХЯ, ГИХГ, "Лау Лау" ХХК нь "Барилгын ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан. Гэрээний дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргад 05 дугаар сарын 28-ны өдрийн 17/93 дугаар албан бичгээр хуучин барилгыг нураах зөвшөөрөл, 06 дугаар сарын 03-ны өдрийн 17/97 дугаар албан бичгээр барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авах хүсэлтийг тус тус хүргүүлсэн. | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 87 хувь | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 2.Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.** (Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмжийн сэргэлт 6.1), (Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 7.3.7) | | | | | | | |
| Зорилт 1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт<br>Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 2.1.1 | Мэдээллийн аюулгүй байдлын стандарт MNS ISO270001:2023 нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх, зөвлөх үйлчилгээ авах | Урсгал зардал | Үнэлгээ хийлгэсэн эсэх; Зөвлөх үйлчилгээ авсан эсэх | - | 1/1 | Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамаар дамжуулан Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засаг, сангийн яамны Мэдлэг хуваалцах хөтөлбөр /KSP/-ийн сонгон шалгаруулалтад мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ авах төслийн саналыг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн бөгөөд уг төсөл эхний шатны шалгаруулалтад тэнцсэн. Үүнтэй холбогдуулан Солонгосын талаас ирүүлсэн ТЭЗҮ боловсруулах болон төсөлтэй холбоотой асуулгын дагуу шаардлагатай мэдээллийг бэлтгэн 01 дүгээр сарын 23, 26-ны өдрүүдэд и-мэйлээр хариу хүргүүлсэн.<br>Мөн Тагнуулын ерөнхий газрын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын газраар 2025 оны 4 дүгээр улиралд хийлгэсэн мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 02 дугаар сарын 05-ны өдөр тус газарт хүргүүлсэн. Мөн 04 дүгээр сарын 21-ний өдөр Мэдээллийн аюулгүй байдлын газраас системийн шалгалт, 05 дугаар сарын 15-ны өдөр ТЕГ-аас ТЕГ03/326 дугаартай зөвлөмж тус тус ирүүлсэн ба хэрэгжилтийг хангасан. Ингэснээр байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлийн түвшин, сайжруулах шаардлагатай чиглэлүүд тодорхой болж, MNS ISO/IEC 27001:2023 стандартыг үе шаттай нэвтрүүлэх бэлтгэл ажлын суурь нөхцөл бүрдсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэ ондоо багтаан мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ хийх эрх бүхий байгууллагаас үнийн санал, ажлын төлөвлөгөө авч, эрсдэлийн үнэлгээ хийлгэн цаашлаад зөвлөх үйлчилгээ авахаар судалж байна. | |
| 2.1.2 | “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг үүлэн тооцоолол (Cloud computing)-д шилжүүлэх | Урсгал зардал | Үүлэн тооцоололд шилжүүлсэн эсэх | - | 1 | Үндэсний Дата төв УТҮГ-аас 03 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн мэдэгдлийн дагуу “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийн 39 сервер, eimmigration.mn системийн 1 сервер, визийн анкет цахим хэлбэрээр мэдүүлэх e-form.mn программд ашиглагдаж байгаа 1 серверийг 04 дүгээр сарын 10-ны өдөр Үндэсний Дата төвийн үүлэн тооцооллын шилжүүлсэн. | 100 |
| 2.1.3 | Баримт бичгийн хуурмаглалыг таних мэдээллийн системийг хөгжүүлэх | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн эсэх | - | 1 | FIELDS (Frontex-INTERPOL Electronic Library Document System) нь INTERPOL болон Европын Холбооны Хил, эргийн хамгаалалтын агентлаг (Frontex)-ийн хамтарсан санаачилгаар бий болгосон, хил хамгаалалт болон зорчих баримт бичгийн хяналтын үйл ажиллагаанд ашиглагддаг олон улсын мэдээллийн сан юм. FIELDS системийг ашиглахтай холбоотой INTERPOL, ХХЕГ, ШШЕГ, ЦЕГ, ГИХГ-ын төлөөлөл оролцсон ажлын цахим уулзалтыг 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. | 30 |
| 2.1.4 | Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх | Урсгал зардал | Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь;<br>Хэвлэх төхөөрөмжийн тоо | 100/5 | 100/5 | Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор 3 ширхэг оршин суух үнэмлэх хэвлэх киоск машин худалдан авах ДГАЗҮСЗДТГ/20250102048 дугаар тендер шалгаруулалтыг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зарлан тендерт шалгарсан байгууллагаас төхөөрөмжүүдийг 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч, 04 дүгээр сарын 27-ны өдөр 1 төхөөрөмжийг Дорноговь аймаг дахь газарт суурилуулан | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглаж эхэлсэн ба 2 төхөөрөмжийг Баруун бүс дэх газар, Зүүн бүс дэх газарт 6 дугаар сард хүргүүлэн ашиглахаар төлөвлөж байна. Байгууллагын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 ширхэг хэвлэх төхөөрөмжийг нэмж авахаар ДГАЗҮСЗДТГ20260102003 дугаар тендер шалгаруулалтыг зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Нийлүүлэгч байгууллага 06 дугаар сарын 09-ний өдөр тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөхөөр мэдэгдээд байна. | |
| 2.1.5 | Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хиймэл оюун (AI)-д суурилсан дуудлага мэдээллийн системийг нэвтрүүлэх | Урсгал зардал | Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх;<br>Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | - | 1/100 | Хиймэл оюун (AI)-д суурилсан дуудлага мэдээллийн системийг нэвтрүүлэх хүрээнд “Хиймэл оюунд суурилсан автомат харилцааны систем” болон “Хиймэл оюунд суурилсан дуу хоолойн харилцааны систем”-ийн техникийн даалгаврыг боловсруулж, архитектурын ерөнхий шийдэл болон логик загварчлалыг эцэслэн гаргасан. Байгууллагын даргын 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/32 дугаар тушаалаар байгуулсан “Мэдээлэл технологийн үйлчилгээ” үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг 03 дугаар сарын 06-ны өдөр зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгч байгууллагатай 04 дүгээр сарын 13-ны өдрийн ГИХГ/20260103004 дугаар гэрээ байгуулж, системийн хөгжүүлэлтийг эхлүүлэн машин сургалтыг хийж, 90 хувийн гүйцэтгэлтэй байна. | 90 |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 84 хувь | | | | | | | |
| 2 зорилго, 4 зорилт, 49 арга хэмжээ | | | | | | | |
| Үнэлгээ: 85.2 хувь | | | | | | | |

--oo0oo--